

Германы Бундестагийн
тогтоолын үндсэн дээр
хөхиүлэн дэмжсэн:



Холбооны
Хүнс,
хөдөө аж ахуйн яам



ГЕРМАН-МОНГОЛЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ "ТОГТВОРТОЙ
ХӨДӨӨ АЖ АХУЙ" ТӨСӨЛ



CONSULTING GROUP
Generalbeauftragter BMEL
Büro Berlin

ОЛНЫ ӨМНӨ ЯРИХ АРГА ЗҮЙ

Б.Эрдэнэболор, PhD

Хэрэгжүүлэгч байгууллагууд



Түши байгууллага



ГАРЧИГ

1. Ярианы агуулга ямар байх ёстой вэ?
2. Яриаг хэрхэн бэлтгэх вэ?
3. Ярианы бүтэц
4. Ярих урлаг
5. Ярианд реторик дүрслэл ашиглах

1. Яриа ямар байх ёстой вэ?

- Утга нь тодорхой, сонсогчдод сонирхолтой бөгөөд ойлгомжтой
(Зөвхөн ярих юмтай үедээ л ярьж бай!)
- Илтгэгчийн имиж, үзэл бодол нь тодорхой
- Илтгэгч сонсогчдыг хүндэтгэж буй нь мэдэгдэхүйц
- Уриалга нь логик үндэслэл сайтай, сонсогчдын санал бодолтой нийцэхүйц
(эсвэл сонсогчдод тэгж санагдахаар)

Ярианы агуулга

- Эмх цэгцтэй, товч, тодорхой, ойлгоход хялбар (энгийн үг хэллэгтэй, үг, өгүүлбэрүүд нь богино, үйл үг ихтэй)
- Сонсогчдод ойлгомжтой үйлдэл, жишээ, дүрслэлүүдийг хэрэглэх
- Боломжтой бол үзүүлэн таниулах материал ашиглах
- Ярианы хэсгүүдийн хоорондох шилжилтийн хэсгүүдийг зөв томъёолох
- Зөвхөн баталгаатай эх сурвалж ашиглах

2. Яриаг бэлтгэх

- Сонсогчид (Би хэний өмнө ярих вэ?)
- Ярих хийх газар
- Өөр ярих хүмүүс
- Тухайн арга хэмжээний ерөнхий сэдэв
- Миний ярианы сэдэв
- Миний зорилго

Яриаг бэлтгэх

- Ярианы сэдэвтэй холбоотой баримт, материал, жишээ цуглуулж, судлах
- Ярианы зорилгоо тодорхойлох
- Ярианы бүтцээ тодорхойлох (цагаа хуваарилах)
- Сонсогчдын зүгээс ирж болох хариуг тооцоолох
- Яриагаа бичих
- ЯРИАГАА ДАВТАХ (гэрийнхэнтэйгээ буюу найз нөхөдтэйгээ)
- Яриагаа засч сайжруулаад давтах. Дахин засч, дахиад давтах...

Яриаг бэлтгэх (яг ярихын өмнө)

- Ярианы сэдэв, сонсогчдын болон өөрийнхөө имиждэд тохирсон хувцас өмсөх
- Зогсоход тохиромжтой газраа олох
- Зөв зогсч, сонсогчидтой харцаараа холбоо тогтоох
- Биеийн хөдлөл ба амьсгалалтандаа анхаарах
- Цаг нь боллоо гэж бодсон үедээ л эхэл
- Сонсогчидтой тогтоосон холбоогоо салгаж болохгүй
- Индрээс буухын өмнө алга ташилтыг хүлээ!

3. Ярианы бүтэц: Ярианы үе шатууд

1. Сонсогчидтой холбоо тогтоох

- чин сэтгэлийн үгс хэлэх, талархал илэрхийлэх, болсон явдлын тухай ярих гэх мэтээр сэдэв рүүгээ орох “бие халаалт” хийдэг. Гол нь сонсогчдын сонирхлыг өдөөх зорилготой.

2. Анхаарал төвлөрөх үе шат

- Одоо сонсогчдод гол сэдвээ танилцуулах болсон
- Ярианы зорилгоо ч бас хэлэх хэрэгтэй

3. Үндсэн илтгэл

4. Хүч нэмэх

- Хамгийн гол хэсгүүдээ нэгтгэн давтаад, сонсогчдод өгөх гэсэн гол мессеж, уриалгаа тод томруунаар хэл
(ихэнхи сонсогчид ярианы хамгийн сүүлийн хэсгийг мартдаггүй)

Ярианы бүтэц: Асуудал шийдвэрлэх

1. Одоогийн нөхцөл байдлыг тоочиж, тайлбарлна.
2. Асуудал үүссэн шалтгаан болон дутагдлуудыг илрүүлнэ.
3. Зорьж буй нөхцөл байдлаа тодорхойлж, тайлбарлна.
4. Асуудлыг шийдэх хувилбаруудыг танилцуулна.
5. Тодорхой үйл ажиллагаанд сонсогчдыг уриалан дуудна.

Ярианы бүтэц: Үндэслэл дэвшүүлэх

Үндэслэл ямар байх ёстой вэ?

- Сонсогчид зөв үндэслэлийг л хүлээж авдаг. Харин зөв эсэх нь сэдэв ба нөхцөл байдлаас шалтгаалдаг
- Өөрөөр хэлбэл сонсогчдын зөв гэж хүлээн зөвшөөрөх үндэслэлийг л гаргах хэрэгтэй.


Анхаарах зүйлс

- Жинтэй цөөн үндэслэлүүдэд гол анхаарлаа хандуул
- Эсрэг үндэслэлүүдийн талаархи бодлоо илэрхийлэх
- Үндэслэлүүдээ жингээр нь эрэмбэлэх
- Сонсогчдоо дүгнэлтэнд аажмаар хөтөлж чиглүүл

Үндэслэлийн бүтэц

Баримт

Баттай эх сурвалжаас
баримт, мэдээлэл
авах



Учир шалтгаан

Учир шалтгааныг
тодорхой тайлбарлах

Үр дагавар

Үр дагаврыг сайтар таниулах

Зургийн эх сурвалж: Зохиогч

Үндэслэл дэвшүүлэх

- Үндэслэлийг оршил хэсэг буюу богинохон өгүүлбэрээр эхэлнэ.

*Жишээ нь: Хичээлийн үеэр яагаад үймүүлж болохгүй вэ гэвэл...;
эсвэл Хичээлийн үеэр үймүүлж болохгүй. Учир нь...*

- Үндэслэлийг уриалга буюу дүгнэлтээр төгсгөнө.

Жишээ нь: Тэгэхээр миний саяын дурьдсан сурган хүмүүжүүлэх болон сэтгэл зүйн шинжлэх ухааны үндэстэй баримт нотолгоонууд хичээлийн үеэр үймүүлэх нь буруу гэдгийг тодорхой харуулж байна

4. Ярих урлаг



Илтгэгчийн гадаад төрх

Зогсолт

- хөл бага зэрэг хазгай, хөлийн үзүүр гадагш
- өвдөг сул чөлөөтэй
- мөрөө хавчихгүй байх
- гэдэс, өгзөгний булчингаа суллах
- гараа бага зэрэг нугална
- гар биеийн өмнө талд

Нүүр царай

- Ярих үед сонсогчдод уруул чинь харагдах ёстой
- Инээмсэглэл!
- Харцаараа сонсогчдыг олзол!

Илтгэгчийн гадаад төрх

Биеийн хөдлөл

- Байгаагаараа бай
- Зөвхөн яриандаа зохицсон хөдөлгөөн л хий
- Хэрэв хөдөлбөл үүнд хоёр гараа, эсвэл бүх биеэ оролцуул
- Хоёр гараа толгой, ташааны хооронд байлга

Амьсгалалт

- Гэдсээрээ, аажуу тайван амьсгала

Хүн мэдээллийн 55%-ийг харж, 38%-ийг сонсож, 7%-ийг утгачилж хүлээж авдаг.

Ярихад тааламжтай нөхцөл бүрдүүлэх

Яриаг эхлэхээс өмнө:

- Хамгийн тааламжтай зогсолтоор зогс
- Гүнзгий амьсгаа ав
- Хүмүүс рүү нөхөрсгөөр тайван хар
- Эхний хэдэн секундэд түшиг болох сонсогчдыг хайж ол.

(Танхимын баруун, зүүн, төв хэсэгт тус бүр 1 хүнийг тогтоогоод ярих үедээ зөвхөн нэг чигт ширтэх биш энэ 3 хүн рүүгээ ээлжлэн харцаа шилжүүлэхэд нийт танхимд цугласан бүх хүмүүст хандан ярьж буй сэтгэгдэл төрүүлнэ)

Ярианы хэмнэлийг тохируулах

- Тайван ярих
- Үгээ тод хэлэх
- Ярианы чанга сулыг тохируулах:
 - Ярианы сэдэв, уриалга
 - Танхимын хэмжээ
 - Сонсогчдын тоо, байршил
 - Микрофонтой эсэх
- Ярианыхаа явцад хамгийн чухал хэсгүүд дээр ярианыхаа өнгийг өөрчилж, удаашруулах
- Үе үе яриагаа завсарлах

Ярих үедээ анхаарах зүйлс

- Онигоо ярих осолтой!
- Тушаал биш, зөвхөн санал л хэлж бай!
- Сэтгэлээсээ ярь!
- Үргэлж сонсогчдыгоо анхаарлын төвд байлгаж, тэднийг уйдаахгүйг хичээ!
- Хэн нэгнийг бусдын өмнө бүү доромжил!
- Гадаад үг, мэргэжлийн хэллэг бага хэрэглэ!

Ярианы тактик

- Дүрслэлтэй ярих

- Жишээ, харьцуулалт г.м.

- Нухацтай ярих

- Давталт

- Хүч оруулах хэллэг ашиглах

- Уриа, уриалгуудыг тохиромжтой үед ашиглах

- Сонсогчдыг сэдэвтээ татан оролцуулах

- Бид одоо яавал зохих вэ?

- Та бүхний мэдэж байгаачлан...

- Энэ танхимд сууж буй зарим нэг хүн ... гэж бодож байж болох юм

- Та бүхэн үүнийг үнэхээр хүсэж байна гэж үү?

Ярих ур чадвараа сайжруулах аргууд

- Дасгал хийх
- Дасгалаа төрөл бүрийн газруудад хийх
- Өөрийгөө болон бусдыг ажиглах
- Бусдын яриа, илтгэлүүдийг судлах
- Үгийн баялагаа сайжруулах
- Дуу хоолой, хэллэгээ сайжруулах

Ярих урлагийн 13 алтан дүрэм

1. Аажуухан хэмнэлээр тод ярь
2. Нийлмэл өгүүлбэр бага хэрэглэ
3. Дуугаа өгүүлбэрийн эхэнд болон төгсгөлд намсгаж, харин дунд хэсэгт нь өндөрсгө
4. Үе үе завсарлага авч бай
5. Бусдыг бүү дуурай, өөрөөрөө л бай
6. 1Б=1Ө (1 бодол = 1 өгүүлбэр)
7. Нэг өгүүлбэрийг 10 секундэд багтааж хэл
8. Давтаж хэлэхээс бүү ай
9. Үйлийн эзэнтэй өгүүлбэрүүдээр ярь
10. Олон нэр үг цувруулж хэлэх нь нуршуу болдог учраас үйл үг аль болох их хэрэглэ
11. Жишээ, дүрслэл сайн хэрэглэ
12. Хамгийн богино ярианд ч гэсэн дунд нь дор хаяж 2 удаа завсарлага ав
13. Сонсогчидтойгоо зөвхөн үгээр биш, бас харцаараа ярь

5. Ярианд реторик хэллэг ашиглах

- Ярианы утга санааг тодруулж, сонирхолтой болгохын тулд реторик хэллэгүүдийг ашигладаг
- Реторик хэллэгүүд нь жирийн ярианд тэр бүр хэрэглэгддэггүй “хэтрүүлэг”-үүд юм.
- Яриаг хоол гэвэл реторик хэллэг давс нь

Реторик хэллэгүүд

Авианы дүрслэл	Үгийн дүрслэл	Өгүүлбэрийн дүрслэл	Утгын дүрслэл
Тодорхой үгс буюу өгүүлбэрийн дуудлагад нөлөөлнө	Тодорхой үгсийн буюу холбоос үгсийн утгад нөлөөлнө	Өгүүлбэрийн бүтцийг жирийн хэрэглээнээс өөрчилнө	Текстийн хэсгүүдийн утга санаанд нөлөөлнө
Үсгээр толгой холбох Үгээр толгой холбох Сүүл холбох	Аккумуляц Хүч нэмэх Давталт Ахиц оруулах Зөвшөөрсөн эсэргүүцэл	Солбио үгс Хураангүй өгүүлбэр Параллелизм Цуварсан өгүүлбэрүүд Цейгма	Апостроф Хэтрүүлэг Егөөдөл Зураглал Авцалдаагүй холбоос Персонификац

Авианы хэллэг

Дүрслэл	Жишээ
Үсгээр толгой холбох	Хэм хэмжээ, цэцэн цэлмэг, хөгшин хөвөө, нөмөр нөөлөг... Идсэн эрүү хувхайрч, идүүлсэн бут цэцэглэнэ Мал нь арвижиж, малчин нь баяжих болтугай!
Үгээр толгой холбох	Хэл, хил, мал гуравтайгаа байхад хэн баян бэ, Монгол баян Хэл, хил, мал гурваасаа хагацвал хэн эмгэнэлтэй вэ, Монгол эмгэнэлтэй
Сүүл холбох	Ургац тогтвортой байх эсэх нь үрийн чанараас л хамаардаг Бордоо, пестицид хичнээн ч хэрэглэсэн ургацын хэмжээ мөн л үрийн чанараас хамаардаг Тэгвэл газар тариалангийн компанийн ашиг орлого юунаас хамаардаг вэ, ерөөсөө л үрийн чанараас хамаардаг

ҮГИЙН ХЭЛЛЭГ

Дүрслэл	Тодорхойлолт	Жишээ
Аккумуляц	Тодорхой харъяалалд багтах нэр үгнүүдийг жагсааж хэлэх	Хар тарлан байна уу, Алатау байна уу, эсвэл Талын улаан нь байна уу, энэ нутгийн нөхцөлд дасан зохицож, өндөр ашиг шим өгч чадах л үүлдэр бидэнд хэрэгтэй байна.
Хүч нэмэх	Нэр үгэнд угтвар нэмж, хүч оруулах	Энэ сортыг тарьсан 10 жилд бид <u>ганц ч удаа</u> ургац алдаж үзээгүй юм шүү!
Давталт	Үгийг буюу өгүүлбэрийн үеийг давтан хэлэх	Энэ бордоог цацаад үз үз! Энэ сортын төмс Говь-алтайн элсэрхэг хөрсөнд ч ургана, Сэлэнгийн шаварлаг хөрсөнд ч ургана.
Ахиц оруулах	Хэллэгийн утга санааг алхам бүрээр ахиулах	Энэ ажлын үр дүнг харахад бидэнд хэдэн сар, магадгүй хэдэн жил шаардагдана.
Зөвшөөрсөн эсэргүүцэл	Зөвшөөрснөө эсэргүүцэх хэлбэрээр илэрхийлэх	Ямар ч байсан боломжгүй биш. Бэлчээрийг хувьчлах асуудалд төр хойрго хандаж байгааг буруутгахгүй байх аргагүй.

Өгүүлбэрийн хэллэг

Дүрслэл	Тодорхойлолт	Жишээ
Солбио үгс	Өгүүлбэрийн хэсгүүдийг харьцуулах хэлбэрээр дараалуулахдаа доторхи үгсийг нь эсрэгээр байрлуулах	Гаргасан зардал бол яриангүй ихэдсэн, харин багадсан юм гэвэл олсон ашиг л байна. Үрийн чанар муудсан гэж та хэллээ, харин би үрийн чанар сайжирсан гэж үзэж байна.
Хураангуй өгүүлбэр	Өгүүлбэрийг товчилж хэлэх	Ноднин бензин хямд байхад манай сумын компаниуд бас ч гэж ашигтай ажиллаж байлаа. Харин одоо?
Параллелизм	Өгүүлбэрийн хэсгүүд ижил бүтэцтэй	Гербицид цацаж хог ургамал, харин инсектицид цацаж хортон шавьж устгадаг.
Цуварсан өгүүлбэрүүд	Энгийн, богино өгүүлбэрүүдийг цувуулан хэлэх	Шуурга намддаггүй ээ. Бэлчээр цасанд дарагдлаа. Малд идэх өвс алга.
Цейгма	Олон нэр үгийг нэг үйл үгээр холбох	Ходоодоороо биш толгойгоороо сэтгэ!

УТГЫН ХЭЛЛЭГ

Дүрслэл	Тодорхойлолт	Жишээ
Апостроф	Сонсогчид руу гэнэт хандах	Өнөөдөр та бүхэнд танилцуулж буй энэхүү шинэ бүтээл нь зөвхөн бидний ажлын үр дүн биш, харин тариаланчид та бүхний бидэнтэй хамтран ажилласны үр дүн билээ.
Хэтрүүлэг	Хэтрүүлэг	Энэ хүнд цаг үед малаа өсгөж, орон нутгийнхаа хөгжлийн хүнд ачааг үүрч яваа малчдыгаа би баатрууд гэж нэрлэмээр байна.
Егөөдөл	Хэлэх гэснээ эсрэг утгаар нь илэрхийлэх	Энэ трактор ч буянтай юмаа. 3 хүнийг ажилтай болгож байна. Нэг нь жолоодоод, хоёр нь араас нь түрээд л.
Зураглал	Зураглаж хэлэх	Энэ үнээний сүү нь маш өтгөн, яг л сарлагийн сүү гэсэн үг.
Авцалдаагүй холбоос	Бодитоор байх боломжгүй холбоос үгс	Малгүй малчин Зохиомол үнэн
Персонификац	Эд зүйлст хүн шиг хандах	Ажил хүнийг голохоос биш хүн ажлыг голох учиргүй.

Ашигласан эх сурвалж

Эрдэнэболор, Б. (2009). Реторик - Ярих урлаг. Интернет хаяг: <https://www.slideshare.net/erdenebolor/ss-86390187> (2020 оны 5-р сарын 12-нд хандсан)